



ГЭМТГЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 4/59

Улаанбаатар хот

Ажлын үр дүнгийн мөнгөн  
урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Байгууллагын дотоод журмын 3.2.1, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ажилтнуудад гүйцэтгэлийн үнэлгээ улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг нийт ажилтнуудад танилцуулж, мөрдөж ажиллахыг дэд захирал, нийт тасаг албадын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Журмын дагуу үнэлэгдсэн хувиар ажилтнуудад мөнгөн урамшууллыг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс
4. эхлэн тооцож улирал бүр бодож, олгохыг Санхүү, бүртгэлийн алба /Ц.Энхбаяр/-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулан мөрдөж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба /Б.Бат-Оргил/-д даалгасугай.
6. Дээрх тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2019 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 113/A тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ГАЛБАДРАХ



202000125

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
Ерөнхий захирлын 2020 оны 06 дугаар сарын  
09.... өдрийн 16 дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ ТӨВ  
ПЛАНУҮЛСҮҮ  
УЛААНБАТЫР ХОТ

ГССҮТӨВИЙН АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ,  
МӨНГӨН УРАМШУУЛАЛТ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар болон 395 дугаар тогтоол, ГССҮТӨвийн дотоод журмыг мөрдлөг болгож, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн ажилтнуудад ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалт олгоход мөрдөнө.
- 1.2. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу сар бүр дүгнэж, түүнийг үндэслэн нөхцөл хангасан ажилтанд мөнгөн урамшуулалт улиралд нэг удаа олгоно.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Эрүүл мэндийн тухай хуулийн:

- 3.1.5. "эмнэлгийн мэргэжилтэн" гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их, бага эмч, шүдний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн;
- 3.1.6. "эрүүл мэндийн ажилтан" гэж эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтан;

### ГУРАВ. УРАМШУУЛАЛ ОЛГОГДОХ ҮНДСЭН НӨХЦЛҮҮД

- 3.1. Эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтан нь ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан байгууллагын үндсэн ажилтан байна.
- 3.2. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс дээш хувьтай байна.
- 3.3. Өвчтэй, чөлөөтэй байсан ажилтанд урамшууллыг ажилласан хоногт хамаарах хувиар тооцож олгоно.
- 3.4. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 20 хүртэл хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно.
- 3.5. Сахилгын шийтгэл ноогдуулсан ажилтанд байгууллагын дотоод журмын дагуу Ерөнхий захирлын тушаалаар хугацаанаас нь өмнө сахилгын шийтгэлийг хүчингүйд тооцсон тохиолдолд урамшууллыг тушаал гаргасан өдрөөс эхлэн тооцон олгоно.

### ДӨРӨВ. УРАМШУУЛАЛ ОЛГОГДОХГҮЙ БАЙХ ҮНДСЭН НӨХЦЛҮҮД

4.1. Доорхи шалгуур үзүүлэлтийн аль нэг заалтыг хангаагүй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзахгүйгээр урамшуулал олгохгүй.

- 4.1.2. Мэргэшил эзэмших болон мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан хугацаанд;
- 4.1.3. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ээлжийн амралт эдлэх хугацаанд;
- 4.1.4. Ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл авсан бол сахилгын шийтгэл эхэлсэн сараас нь эхлэн сахилгын шийтгэлийг дуусах хүртэл хугацаанд;
- 4.1.5. Тайлант сард эмнэлгийн тусlamж, үйлчилгээний зөрчил гаргасан нь батлагдсан тохиолдолд;
- 4.1.6. Тайлант сард ажилтантай холбоотой ёс зүйн хэм хэмжээний зөрчил, гомдол гаргасан нь батлагдсан тохиолдолд үйлчлүүлэгч болон ажилтнаас ирүүлсэн гомдол, өргөдлийг үндэслэн;
- 4.1.7. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь эмнэлгийн нөхцөлд зохистой хувцаслах дүрмийг мөрдөөгүй;
- 4.1.8. Тухайн сард эмнэлгийн ажилтан нь хүндэтгэх шалтгаангүйгээр ажлын цагийн хоцрогдолтой;
- 4.1.9. Тухайн сард эмнэлгийн ажилтан нь эмнэлгийн захиргаа, холбогдох албан тушаалтанд урьдчилан мэдэгдэлгүйгээр ажил тасалсан;
- 4.1.10. Байгууллагад хийгдсэн шалгалт, хяналт үнэлгээгээр зөрчил гаргасан;
- 4.1.11. Эмнэлгийн захиргаа, алба, тасгийн эрхлэгчээс тухайн сард төлөвлөгдсөн болон ажлын шаардлагаар яаралтай өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй;
- 4.1.12. Туршилтын болон Хөлсөөр ажиллах гэрээгээр, дагалдан ажиллуулах хугацаанд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтанд урамшуулал олгохгүй.
- 4.1.13. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 71-ээс доosh хувьтай байгаа тохиолдолд тус тус урамшуулал олгохгүй.

#### ТАВ. САР БҮР АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ АЛБАН ТУШААЛТАН

5.1. Байгууллагын Ерөнхий захирал нь дэд захирлууд, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга, Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ чанар, аюулгүй байдлын албаны дарга, Захирлын ажлын албаны дарга нарын ажлын үр дүнг дүгнэнэ.

5.2. Дэд захирлууд нь өөрийн харьяалах албадын дарга, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүнг дүгнэнэ.

5.3. Албадын дарга, тасгийн эрхлэгч нар нь өөрсдийн хариуцан ажиллаж байгаа нэгжийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын ажлын үр дүнг сар бүр батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

5.4. Эрүүл мэндийн мэргэжилтэн болон ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэсэн үнэлгээг алба, тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, тэмдэглэл хөтөлсөн байна.

5.5. Эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтны сарын ажлын үр дүнгийн үнэлгээг алба, тасгийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн удирдлагын зөвлөлөөр

хэлэлцэж, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг улирал бүр Ерөнхий захирал гаргана.

5.6. Байгууллагын нэгжийн удирдлага буюу албадын дарга, тасгийн эрхлэгч нар нь өөрсдийн хариуцсан алба, тасгийн эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтны үр дүнгийн үнэлгээг хийж, хамт олны хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлт, хурлын тэмдэглэлийн хамт сар, улирал бурийн 6-ны дотор харьяа удирдлага болох Дэд захирлуудад ирүүлнэ.

5.7. Эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтны сарын үр дүнгийн үнэлгээ, хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг харьяа дэд захирлууд эмнэлгийн удирдлагын зөвлөлд танилцуулж, эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг Ерөнхий захирал гаргана.

#### ЗУРГАА. САР БУРИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ НЭГДСЭН АРГАЧЛАЛ

6.1. Эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтны ажлын, үр дүнгийн мөнгөн урамшууллыг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, шаардлага хангасан тохиолдолд улирал тутам батлагдсан төсөвт багтаан зохих суутгалуудыг суутгаж тооцож олгоно.

6.2. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн болон үр дүнгийн үнэлгээг:

- "Бүрэн хангалттай А" – 90-100 оноо,
- "Хангалттай" Б – 71-89 оноо,
- "Хангалтгүй" – 70 ба түнээс доош оноогоор гэсэн үнэлгээгээр сар бүр дүгнэнэ.

#### Ажлын үр дүнгийн үнэлгээ

Засгийн газрын тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эмнэлгийн мэргэжилтэн болон ажилтны ажлын үр дүнг сар бүр үнэлэх ба үнэлгээний нийт хувиас хамаарч, дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшууллын хэмжээг тооцно.

Бүх шалгуурын биелэлтын хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшуулал тооцох хувь / сард /
100	Бүрэн хангалттай буюу А	20,0%
99		19,5%
98		19,0%
97		18,5%
96		18,0%
95		17,5%
94		17,0%
93		16,5%
92		16,0%
91		15,5%
90		15,0%
89	Хангалттай буюу Б	14,5%
88		14,0%
87		13,5%
86		13,0%
85		12,5%

84		12,0%
83		11,5%
82		11,0%
81		10,5%
80		10,0%
79		9,5%
78		9,0%
77		8,5%
76		8,0%
75		7,5%
74		
73		7,0%
72		
71		
70 ба түүнээс доош	Хангалтгүй	Үр дүнгийн урамшуулал олгохгүй

Жич: Онооны нарийвчлалыг доорхи байдлаар ойлгож хэрэглэнэ.

- 0-0,5 бол 0
- 0,51 дээш бол 1

#### Ажлын цаг ашиглалтын үнэлгээ

Ажлын цагийн ашиглалтын үнэлгээнд цагийн бүртгэлийн ZKTime 5.0 программыг ашиглах ба дараахь байдлаар үнэлнэ.

Цагийн бүртгэлийн программ дахь ирцийн хувь /A/	Үүнээс: Хүндэтгэн үзэх шалтгаантай ирцийн хувь /B/	Нийт цаг ашиглалтын хувь /A+B/	Үнэлгээ оноох ирцийн хувь /A+B/	Харгалзах оноо
			100%	10
			99%	9
			98%	
			97%	
			96%	
			95%	
			94%	
			93%	
			92%	
			91%	
			90%	8
			89%	
			88%	
			87%	
			86%	
			85%	
			84%	
			83%	

		82%	7
		81%	
		80%	
		79%	
		78%	
		77%	
		76%	
		75%	
		74%	
		73%	
		72%	
		71%	

## ДОЛОО. АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАХ, БАТАЛГААЖУУЛАХ, ОЛГОХ

7.1. Эмнэлгийн мэргэжилтний үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг журмын 1 дүгээр хавсралтаар, Эрүүл мэндийн бусад ажилтны шалгуур үзүүлэлтийг журмын 2 дугаар хавсралтаар тус тус заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын үр дүнг тухайн ажилтны ажиллаж байгаа нэгжийн удирдлага албаны дарга, тасгийн эрхлэгч, бага эмч нар дүгнэж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрийг цэвэр гаргацтай бичиж, хурлын тэмдэглэлийн хамт дараа сарын 05-ны дотор харьяа дэд захирлуудад хүргүүлнэ.  
*/Дараа сарын 05-ны өдөр нь амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт нь өгнө/*

7.2. Харьяа дэд захирлууд нь журмын хавсралтад заасан шалгуурын үнэлгээнд хяналт тавьж, холбогдох албан тушаалтнуудаар дараа улирлын эхний сарын 06-аас 08-ны өдрүүдэд баталгаажилт хийлгэнэ */Дараа улирлын 06-аас 08-ны өдөр нь амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт нь өгнө./*

7.3. Ерөнхий захирлын ажлын үр дүнг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.

7.4. Мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сарын 25-ны дотор олгоно.

7.5. Ажилтнуудын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын хэмжээг дараах байдлаар баталгаажуулна:

7.5.1. Ерөнхий захирал нь удирдлагын зөвлөлийн гишүүдийн;  
*/Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга хамаарахгүй/*

7.5.2. Эмнэлгийн тусlamж үчилгээ хариуцсан дэд захирал нь өөрийн харьяалалын эмнэлзүйн тусlamж, үйлчилгээ үзүүлдэг тасаг нэгжүүдийн эрхлэгч нарын;

7.5.3. Эрдэм шинжилгээ, төлөвлөлт хариуцсан дэд захирал нь нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, төлөвлөлт, гадаад харилцаа, статистик мэдээлэл, тандалт судалгаа зэрэг харьяалах албадуудын нийт ажилтнуудын;

7.5.4. Мэдээлэл технологи, хангамж үйлчилгээ хариуцсан дэд захирал нь инженер техник, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээллийн технологи, аж ахуй, хангамж үйлчилгээний зэрэг харьяалах албадуудын нийт ажилтнуудын;

7.5.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга нь харьялах албаны ажилтнууд, шүүх эмнэлгийн ажилтнуудын;

7.5.6. Тасгийн эрхлэгч, албадын дарга нар нь өөрийн хариуцсан нэгжийн нийт ажилтнуудын;

7.5.7. Санхүү бүртгэлийн албаны дарга нь харьялах албаны эдийн засагч, нягтлан бодогч, бусад ажилтнуудын;

7.5.8. Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга нь албандаа харьялах ажилтнуудыг;

7.5.9. Сувилахуйн албаны дарга нь албандаа харьялах ажилтнуудын;

7.5.10. ЭМТҮ-ний чанар, аюулгүй байдлын албаны дарга, Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга нар нь нийт тасаг нэгжийн ажилтнуудын ажлын үр дүнгийн үнэлгээнд өөрийн хариуцсан ажил үүргийн чиглэлээр хяналт хийж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

#### Мөнгөн урамшууллын хувь хэмжээ

Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран урамшууллын хувь хэмжээг дараах байдлаар олгоно.

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Олгох урамшууллын хувь
90-100	Бүрэн хангалттай	15-20 хувь
71-89	Хангалттай	7-14 хувь
70 ба түүнээс доош	Хангалтгүй	Урамшуулалт олгохгүй

#### **НАЙМ. ХЯНАЛТ**

8.1. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, үнэлгээнд тасгийн эрхлэгч, албаны дарга, ахлах сувилагч нар хяналт тавина.

8.2. Тасгийн эрхлэгч, албаны даргын ажлын үр дүн, үнэлгээнд харьяа дэд захирлууд хяналт тавина.

#### **ЕС. ХАРИУЦЛАГА**

9.1. Товлосон хугацаанд хамт олны хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлтийг дараа улирлын 05-ны дотор өгөөгүй, улирлын 08-ны дотор баталгаажилт хийгээгүй албан тушаалтны мөнгөн урамшууллаас маргах нөхцөлгүйгээр 5 хувийг хасч хариуцлага хулээлгэнэ.

9.2. Эрх бүхий албан тушаалтны гаргаж өгсөн оноог санаатай болон санамсаргүй байдлаар зассан ажилтан, албан тушаалтны мөнгөн урамшууллаас маргах нөхцөлгүйгээр 5 хувийг хасч, хариуцлага хулээлгэнэ.

**Эмнэлгийн мэргэжилтний үр дүнг үнэлэх**

Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн үзүүлэлт	Шалгуур	Дүгнэх албан тушаалтан	Хянах албан тушаалтан	Гүйцэтгэлийн үнэлгээ
<b>A. Нийтлэг шалгуур үзүүлэлт</b>					
Үйлчилгээний чанар	Гэмтэл согогийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байдал	Хүлээгдэл чирэгдэлгүй үйлчилсэн байх	Ажилтны үнэлгээг тасаг, албаны дарга Тасаг, албаны даргын үнэлгээг харьялах дэд захирлууд үнэлнэ.	ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга	10
	Ес зүй, харилцааны байдал /нотлогдсон зөрчил, өргөдөл гомдол/	Нотлогдсон өргөдөл гомдол, зөрчил			10
	Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	Сэтгэл ханамжийн судалгаа, хайрцагаар болон бичгээр ирсэн талархал, санал, хүсэлт			10
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажлын цагийн бүртгэл	Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга	Санхүү бүртгэлийн албаны дарга	10
	Ажлын ачаалал	Ажлын цаг ашиглалт			5
	Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	Хариуцсан өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдал			5
	Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	Анхан шатны бичиг баримт хөтлөлт, сар бүрийн тайлан өгөлт			10
Эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Эмчилгээ, үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, здийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	Хийгдсэн бодит ажил	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал	Санхүү бүртгэлийн албаны дарга	2
	Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санаал, санаачлага гарган ажилласан байдал	Хийгдсэн бодит ажил			2
	Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Байгууллагаас зохион байгуулсан ажилд оролцсон идэвхи, бүртгэл			6
<b>B. Тусгай шалгуур үзүүлэлт</b>					
Эмнэлгийн тусламж, үйчилгээний чанар	Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдеж байгаа байдал	Стандарт үнэлгээ	Ажилтны үнэлгээг тасаг, албаны дарга Тасаг, албаны даргын үнэлгээг харьялах дэд захирлууд үнэлнэ.	ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга	10
	Халдвэр хамгааллын дэглэмийг мөрдеж байгаа байдал	Хөдөлмер хамгааллын дэглэмийн үнэлгээ			5
	Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан нотлогдсон гомдол	11-11 утсанд ирсэн болон бичгээр ирүүлсэн нотлогдсон гомдол, өргөдөл			5
	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал	Хот, орон нутагт мэргэжил арга зүйн зөвлөгөө, эмчилгээний зөвлөгөө, сургалт сурталчилгаа, TV радио, сонин хэвлэлд мэдээлэл өгсөн байдал			5
	Ажлын байрны тодорхойлолт заасан ажлын гүйцэтгэл, чанар	Ажлын байрны тодорхойлолт заасан ажлын гүйцэтгэл			5

Дүгнэсэн: Тасгийн эрхлэгч/Албаны дарга \_\_\_\_\_  
Бага эмч \_\_\_\_\_

Хянасан: ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга \_\_\_\_\_  
Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга \_\_\_\_\_  
Санхүү бүртгэлийн албаны дарга \_\_\_\_\_

Нийт оноо-100

**Эмнэлгийн бусад ажилтны ажлын үр дүнг үнэлэх шалгуур**

Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн үзүүлэлт	Шалгуур	Дүгнэх албан тушаалтан	Хянах албан тушаалтан	Гүйцэтгэлийн үнэлгээ
<b>A. Нийтлэг шалгуур үзүүлэлт</b>					
Үйлчилгээний чанар	Гэмтэл согогийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байдал	Хүлээгдэл чирэгдэлгүй үйлчилсэн байх	Ажилтны үнэлгээг тасаг, албаны дарга Тасаг, албаны даргын үнэлгээг харьялах дэд захирлууд үнэлнэ.	ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга	10
	Ес зүй, харилцааны байдал /нотлогдсон зөрчил, өргөдөл гомдол/	Нотлогдсон өргөдөл гомдол, зөрчил			5
	Үйлчлүүлэгч, хамт олны сэргэл ханамжийн байдал	Сэтгэл ханамжийн судалгаа, хайрцагаар болон бичгээр ирсэн талархал, санал, хүсэлт			10
Ажлын ачаалал, хариуцлага	Ажлын цаг ашиглалт	Ажлын цагийн бүртгэл	Хүний неөцийн хөгжлийн албаны дарга	Санхүү бүртгэлийн албаны дарга	10
	Ажлын ачаалал	Ажлын цаг ашиглалт			5
	Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт	Хариуцсан өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдал			10
	Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	Анхан шатны бичиг баримт хөтлөлт, сар бурийн тайлан өгөлт			10
Эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	Шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, здийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	Хийгдсэн бодит ажил	Хүний неөцийн хөгжлийн албаны дарга	Санхүү бүртгэлийн албаны дарга	2
	Ургүй зардлыг багасгах талаар тодорхой санал, санаачлага гарган ажилласан байдал	Хийгдсэн бодит ажил			2
	Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	Байгууллагаас зохион байгуулсан ажилд оролцсон идэвхи, бүртгэл			6
<b>B. Тусгай шалгуур үзүүлэлт</b>					
Хариуцсан ажлын чанар	Стандартыг мөрдөж байгаа байдал	Стандарт үнэлгээ	Ажилтны үнэлгээг тасаг, албаны дарга Тасаг, албаны даргын үнэлгээг харьялах дэд захирлууд үнэлнэ	Харьялах дэд захирал	10
	Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	Ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл			10
	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Үүрэг даалгаврын биелэлт, гүйцэтгэл			10

Дүгнэсэн: Тасгийн эрхлэгч/Албаны дарга \_\_\_\_\_  
Бага эмч \_\_\_\_\_

Хянасан: ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга \_\_\_\_\_  
Хүний неөцийн хөгжлийн албаны дарга \_\_\_\_\_  
Санхүү бүртгэлийн албаны дарга \_\_\_\_\_

Нийт оноо-100